



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 8125

Улаанбаатар хот

Г.Цэцэгдуламд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11, 48 дугаар зүйлийн 48.1.6 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.2 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.4, 10.8, 10.17 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Гантөмөрийн Цэцэгдулам нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан “Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй” гэснийг зөрчсөн нь Авлигатай тэмцэх газрын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 05/17852 дугаар албан бичиг, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс албан тушаалын цалингийн хэмжээг гурван сарын хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын ахлах бүртгэгч Г.Цэцэгдуламд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН